



# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 04 өдөр


Дугаар А/91

Улаанбаатар хот

## Япон Улсад багш, судлаачдыг суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/308 дугаар тушаалаар батлагдсан “Япон Улсад инженер, технологийн чиглэлээр коосэн, хамтарсан бакалавр, магистр, доктор, зэргийн бус сургалтын хөтөлбөрт оюутан суралцуулах журам”-ын 2.7, 2.9 дэх заалт, төслийн удирдах хорооны 2015 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн хурлын 09 тоот тогтоол, тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн шугамаар 2014-2015 оны хичээлийн жилээс Япон Улсын их сургуулиудын магистр, доктор сургалтын хөтөлбөрт суралцуулах багш, судлаачдын нэрсийг хавсралт ёсоор баталсугай.
2. Япон Улсад суралцах багш, судлаачидтай журмын дагуу сургалтын зээлийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, Монгол улсын их сургууль /Р.Бат-эрдэнэ/, Шинжлэх ухаан, технологийн их сургууль /Б.Очирбат/ нарт тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /Б.Насанбаяр/-т, Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т, Санхүү, эдийн засгийн газар /Ц.Баярхүү/ -т тус тус үүрэг болгосугай.



Л.ГАНТӨМӨР

Боловсрол, соёл, шинжлэх ухааны  
сайдын 2015 оны 03 дугаар  
сарын 06 ны өдрийн... дугаар  
А/91 тушаалын хавсралт

ЯПОН УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОР СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ 2014-2015 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛЭЭС  
СУРАЛЦАХ БАГШ, СУДЛААЧДЫН НЭРС

Д/Д	Эцэг, (эх)-ийн нэр, нэр	Ажиллаж буй сургууль	Япон Улсад суралцах сургууль	Суралцах хугацаа	Судалгааны чиглэл	Хамрагдах хөтөлбөр
1.	Даваажав Нарантогтох	ШУТИС-ийн багш	Киотогийн технологийн их сургууль	3 жил	Дэвшилтэт материалын судалгаа	Доктор
2.	Орхон Банзрагчгарав	МУИС-ийн эрдэм шинжилгээний ажилтан	Тоохокугийн эм зүйн их сургууль	3 жил	Зелесовын зэдгэлжийн фотохимийн болон биологийн судалгаа	Доктор
3.	Мөнхбат Долгормаа	МУИС-ийн эрдэм шинжилгээний ажилтан	Миязакигийн их сургууль	2 жил	Дэвшилтэт материалын судалгаа хүрээлэн буй орчны инженерчлэл	Магистр
4.	Эрдэнэдаваа Пүрэвдалай	МУИС-ийн эрдэм шинжилгээний ажилтан	Токиогийн аж үйлдвэр, технологийн их сургууль	3 жил	Сэргээгдэх эрчим хүч, нарны эрчим хүчийг инженерчлэх	Доктор

-----000-----